

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Монголбанкны албан хэрэгцээнд интернетийн үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **Ү -2017/1**

Монголбанк эрх бүхий тендерт оролцогчоос Монголбанкны албан хэрэгцээнд интернетийн үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож байгаа үнийн дүнтэй тэнцүү байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: **2015, 2016 он**

Тендерийн хамт тендерт оролцохоор **санал болгож байгаа үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн** дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 09 дугаар сарын 4-ний өдрийн 14 цаг 00 минутаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 09 дугаар сарын 4-ний өдрийн 14 цаг 40 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,  
Монголбанкны “Өргөтгөл” байрны 2 дугаар давхар, 37 тоот өрөө,  
Утас: (976-11) 311039, факс: (976-11) 311471